



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 02 өдөр

Дугаар A/437

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун-Урт сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй С.Ууганболов захиралтай "Бадмаараг өсөх" ХХК-ийн "Бадмаараг-2" хүнсний дэлгүүр, Асгат сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах А.Отгонзаяа захиралтай "Гурван хадтай" ХХК-ийн "Баян-Өлзий" хүнсний дэлгүүр, Сүхбаатар сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Н.Энхбат захиралтай "Хайлааст дэлгэрэх" ХХК-ийн "Болор" хүнсний дэлгүүр, Халzan сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Баярцэцэг захиралтай "Гал бадрах өөдөө" ХХК-ийн "Арвижих" хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгаж, Баруун-Урт сумын 2-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Д.Тасхүү захиралтай "Мөнх түмэн хур" ХХК-ийн "Баянтэрэм" хүнсний дэлгүүрт өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуйлж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (С.Нямжав), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М. ИДЭРБАТ

2222010862